



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2002 оны 3 сарын 01 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

**"УЛААНБААТАР УС" НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ТАЛААР АВАХ
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2001 оны 180 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. "Улаанбаатар ус" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Ендон овогтой Батболдыг 2002 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн "Улаанбаатар ус" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар томилсугай.
3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны балансын гадуур бүртгэлтэй Улаанбаатар хотын борооны болон хөрсний ус татан зайлуулах инженерийн шугам сүлжээ төмөр бетон хоолой, борооны болон хөрсний ус татан зайлуулах насосны станцын 229 086 700 /хоёр зуун хорин есөн сая наян зургаан мянга долоон зуун/ төгрөгийн хоёрдугаар хавсралт дахь эд хөрөнгийг "Улаанбаатар ус" нийслэлийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлэн хүлээлгэж өгөх ажлыг 2002 оны 3 дугаар сарын 5-ны дотор зохион байгуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /П.Дэлгэрнаран/, Захирагчийн ажлын албаны Хот тохижилтын хэлтэс /Ц.Болд/-т даалгасугай.
4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 1997 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр баталсан "Улаанбаатар ус компани" улсын үйлдвэрийн газрын дүрмийг хүчингүй болгосугай.



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ**

(Handwritten signature)
М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2002 оны 74-р тоот захирамжийн 1 дүгээр хавсралт

“УЛААНБААТАР УС” НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН /НӨҮГ/ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 “Улаанбаатар ус” Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь /цаашид “үйлдвэрийн газар” гэнэ/ Улаанбаатар хотын Захирагчийн харьяа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу Улаанбаатар хотыг үер, хур тунадасны болон хөрсний уснаас хамгаалах, уст цэг байгуулах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд эрхлэн явуулах зорилгоор байгуулагдсан үйлдвэрийн газар юм. Үйлдвэрийн газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар аж ахуйн тооцоооны үндсэн дээр ажиллана.

1.2 Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон Орон нутгийн Өмчийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын шийдвэрүүд болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3 Үйлдвэрийн газар нь нийслэлийн захиалгаар үйл ажиллагаа явуулж, хийсэн үйлчилгээнийхээ гүйцэтгэлээр хотын төсвөөс санхүүжигдэж болно.

1.4 Үйлдвэрийн газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, бэлэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

1.5 Үйлдвэрийн газар нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 4-р хороо /Хархорин захын баруун тал/-нд байрлана. Утас 631290

Хоёр.Удирдлагын зохион байгуулалт

2.1 Үйлдвэрийн газрын захирлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

2.2 Үйлдвэрийн газрын захирлын эрх, үүрэг, хариуцлага, цалин хөлс, урамшуулал болон бусад харилцааг Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулсан гэрээгээр зохицуулна.

2.3 Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа Улаанбаатар хотын Захирагч, түүний Ажлын албаны удирдлага дор явуулж ажлаа тайлагнана.

2.4 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч үйлдвэрийн газрын дүрмийг батална.

2.4 Үйлдвэрийн газрын захирал нь хөдөлмөрийн дотоод журам, цалин, урамшууллын хэмжээг тогтоож мөрдүүлэх ба албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

Гурав. Үйлдвэрийн газрын үүрэг

3.1 Үйлдвэрийн газар нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэр зам талбайд буусан хур тунадасны болон хөрсний усыг зайлуулах инженерийн шугам сүлжээ, далан суваг, өргөлтийн насосны станцын ажил үйлчилгээ, гүний болон бусад төрлийн худаг усны ажил, худгийн засвар үйлчилгээ болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад ажил үйлчилгээг явуулна.

3.2 Үйлдвэрийн газар нь далан суваг борооны усны шугам сүлжээний үзлэгийн болон хүлээн авах худгууд, бусад тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг технологийн горимын дагуу гүйцэтгэнэ.

3.3 Үйлдвэрийн газар нь өргөлтийн насосны станцын хэвийн үйл ажиллагааг хангаж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг техникийн горимын дагуу хийж гүйцэтгэнэ.

3.4 Үйлдвэрийн газар нь борооны ус татан зайлуулах шугам сүлжээнд харъяалагдах зам талбайн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад анхаарч ажиллана.

3.5 Үйлдвэрийн газар нь ажил үйлчилгээний чиглэлийн дагуу байгууллага, иргэдээс ирсэн санал гомдлыг барагдуулах ажлыг зохион байгуулна.

3.6 Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэлээр гарсан хууль тогтоомж, Нийслэлийн удирдлагын шийдвэрийн биелэлтийг хангуулах, гарсан зөрчил дутагдлыг арилгуулж хохирлыг барагдуулна.

3.7 Үйлдвэрийн газар нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчныг бохирдлоос хамгаалахад чиглэгдсэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.8 Үйлдвэрийн газар нь үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө шинээр олж авах, бусад этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, шилжүүлэх болон худалдах, данснаас хасахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу асуудлыг шийдвэрлэнэ.

3.9 Үйлдвэрийн газар нь хотыг үер, борооны болон хөрсний уснаас хамгаалах чиглэлээр төсөл, судалгаа хэрэгжүүлэх ажил үйлчилгээг өргөтгөхтэй холбогдуулан тоног төхөөрөмж, сэлбэг, материал олж авах, байгаль орчинд учруулах бохирдлыг багасгах дэвшилтэт технологийг нэвтрүүлхэд анхаарч ажиллана.

Дөрөв. Үйлдвэрийн газрын эрх

4.1 Үйлдвэрийн газрын өмч хөрөнгийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн шийдвэр болон энхүү дүрэмд нийцүүлэн эзэмшиж, ашиглаж захиран зарцуулна.

4.2 Үйлдвэрийн газрын хариуцах ажил үйлчилгээний асуудлаар гадаад орны болон өөрийн улсын холбогдох байгууллагуудтай харилцах, Улаанбаатар хотын Захирагчийн болон холбогдох эрх бүхий байгууллагын олгосон эрхийн дагуу гэрээ хэлцэл хийж хамтран ажиллана.

4.3 Үйлдвэрийн газрыг өргөтгөх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр төр захиргааны байгууллагаас зохиож байгаа төсөл, хөтөлбөрт оролцох, санал дүгнэлтээ тавина.

4.4 Үйлдвэрийн газрын ажлын үр дүнгээр ажиллагсдад нэмэгдэл хөлс олгох, шагнаж урамшуулах, амьдрал ахуйд нь тусалж дэмжих асуудлыг дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

4.5 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх эрхтэй.

Тав. Эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, хяналт

5.1 Үйлдвэрийн газрын эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, тайланг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу явуулна.

5.2 Үйлдвэрийн газар нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

5.3 Үйлдвэрийн газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, татварын алба санхүүгийн байгууллагад тушаана.

5.4 Үйлдвэрийн газар нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

5.5 Үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

5.6 Үйлдвэрийн газрын удирдлага нь үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалаар хангана.

5.7 Үйлдвэрийн газрын тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж буй бусад мөнгөн хөрөнгө, түүнчлэн орлого, зарлага, төлөгдөөгүй өр зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөгт хөрвүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны ханшаар тооцно.

Зургаа. Хариуцлага.

6.1 Үйлдвэрийн газрын албан хаагчид нь байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, гэрээнд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

6.2 Монгол Улсын хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.3 Үйлдвэрийн газрын захирал нь эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашиглах, байгууллагадаа хохирол учруулах болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан хохирлыг өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцна.

Долоо. Бусад

7.1 Энэхүү дүрмэнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

7.2 Энэхүү дүрмэнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.



Нийслэлийн Засаг даргын 2002 оны 74 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Улаанбаатар хотын борооны болон хөрсний ус татан зайлуулах инженерийн шугам сүлжээ төмөр бетон хоолой, насосны станцын эд хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Х/н	Хэмжээ	Нийт үнэ /мян.төг/
	<u>Насосны станц</u>			
1	Насосны станцын барилга	ш	1	56000,0
2	ОХГ-55-И насос	ш	1	6000,0
3	ОХГ-8-55-И насос	ш	1	6000,0
4	ОХГ-8-55-И насос	ш	1	6000,0
5	ОХГ-8-55-И насос	ш	1	6000,0
6	К-45-55 насос	ш	1	800,0
7	30 Ч 936 БК О1000 хаалт	ш	1	210,0
8	30 Ч 936 БК	ш	1	210,0
9	31 Ч 936 БК	ш	1	210,0
10	32 Ч 936 БК	ш	1	210,0
11	30 Ч 936 БК О1000 хаалт	ш	1	210,0
12	О 800 гар хаалт	ш	1	160,0
13	О 800 гар хаалт	ш	1	160,0
14	О 800 гар хаалт	ш	1	160,0
15	О 800 гар хаалт	ш	1	160,0
16	О 800 гар хаалт	ш	1	160,0
17	О 800 гар хаалт	ш	1	160,0
18	О 800 гар хаалт	ш	1	160,0
19	О 800 гар хаалт	ш	1	160,0
20	О 1200 цахилгаан хаалт	ш	1	380,0
21	Таль цахилгаан 5т	ш	1	30,0
22	Таль гар 3т	ш	1	5,0
23	КИП хянах самбар 3	ш	1	240,0
24	КО-504	ш	1	235,0
25	Халаагуур 1х13	ш	1	60,0
26	РД 800 1х3	ш	1	150,0
27	Сейф	ш	1	10,0
	ДҮН			84240,0
	<u>Хотын борооны усны төмөр бетон хоолой</u>			
1	400-гийн төмөр бетон хоолой	у/м	26300	16766,2
2	О1200 төмөр бетон хоолой	у/м	17600	112200,0
3	Лук таг	ш	400	8800,0
4	Ширмэн шүүр суурь	ш	833	7080,5
	ДҮН			144846,7
	БҮГД ДҮН			229086,7